

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН БАЙРАНД СЕРВЕРИЙН ӨРӨӨ, ТҮҮНИЙ
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

1. Зорилго	“Монголын хөрөнгийн бирж” ХК нь мэдээллийн технологийн тогтвортой, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор олон улсын дата төвийн стандартын (TIA/942) жишигт нийцсэн серверийн өрөөг зохион байгуулах ажлыг гүйцэтгэх
2. Инженерийн барилга, байгууламжийн төхөөрөмж суурилуулах үндэслэл	“Монголын хөрөнгийн бирж” ХК нь мэдээллийн технологийн тогтвортой, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор олон улсын дата төвийн стандартын (TIA/942) жишигт нийцсэн суурь дэд бүтэц бүхий серверийн өрөөг TIER II түвшинд нийцүүлэн байгуулах
3. Барилга байгууламжийн байршил	Монголын хөрөнгийн бирж ХК-ийн байр <i>Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс</i>
4. Үндсэн шаардлага	<p>Серверийн өрөөг байгуулах</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын дата төвийн стандартын (TIA/942) жишигт нийцсэн суурь дэд бүтэц бүхий серверийн өрөөг бий болгох - Серверийн өрөө нийт 39.8 м² 109,110-р өрөөнд зохион байгуулах /зураг/, таазны өндөр 6300м - Үүдний өрөө 10.4 м², серверийн өрөө 29.4 м² байна - Серверийн өрөөг 4 технологийн рак, 1 сүлжээ, 1 UPS рактайгаар төлөвлөсөн бөгөөд нийт IT ачаа нь 18.5 киловатт (кВт) байхаар тооцно - Серверийн өрөөний температур 18-27C, чийгшил 40%-55% байхаар тус тус төлөвлөх - Серверийн өрөөний тоног төхөөрөмжийн нүүлгэлт - Аюулгүй байдлын үйл ажиллагаа, мэдээлэл менежментийн программ хангамж /SIEM/ нийлүүлэх суурилуулах тохиргоог хийх - Орчны хяналтын систем /DCIM/ холболт суурилуулалт, тохиргоог хийх - Хүчит төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт, тохиргоо хийх - Галын систем нийлүүлэх суурилуулалт /зургын дагуу зохион байгуулах/ - Серверийн өрөөний зориулалтын хаалга - Серверийн өрөөний зориулалт бүхий хөндий шал - Хүйтэн эгнээний тусгаарлалт /containment, зураг төслийн дагуу/ - Ханын дэлгэц 2x2 layout 3 давхарт хяналтын өрөөнд угсарч суурилуулах, холбох кабелийн мантож хийх /SIEM, серверийн өрөөний нэгдсэн хяналтын системийг холбох/

	<ul style="list-style-type: none"> - Серверийн өрөөнөөс харуул хамгаалалтын ажилтанд камер хянах, дэлгэц холбох кабелийн монтаж хийх (дэлгэц салаалагч, сүлжээний кабель, HDMI) холбох. - Цахилгаан эрчим хүч Үндсэн болон нөөц эх үүсвэр байх бөгөөд, генераторын холболт серверийн өрөөний дотоод цахилгааны ажлыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх
5. Техникийн нарийвчилсан шаардлага	<p>Серверийн өрөөний гал унтраах систем, агааржуулалт, цахилгаан эрчим хүч, хүчит төхөөрөмж, орчны хяналт, мэдээллийн сүлжээ, системийн зураглал техникийн тодорхойлолтын дагуу тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулалтыг хийж гүйцэтгэх</p> <p>Барааны нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэлтийн хуваарь, Холбогдох үйлчилгээний жагсаалт болон гүйцэтгэлийн хуваарийг тус тус ирүүлнэ</p>
6. Хөдөлмөр аюулгүй байдал	<ol style="list-style-type: none"> 1. Угсралтын ажил гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, стандартыг чанд мөрдөж ажиллана. 2. Орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримтална 3. Мэдээлэл, харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага MNS 6869 : 2020 стандарт, MNS 5471 Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт, MNS 5596 Цахилгаан холбооны сүлжээнд ажиллахад тавих аюулгүй ажиллагааны шаардлага, MNS 6588:2016 Мэдээлэл холбооны суурин сүлжээний сувагчлалын хоолойд уян нийлэг дэд сувагчлал суурилуулах ерөнхий шаардлага, MNS 6767:2019 Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуй. Ажлын дайран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага, БД 43-102-07 Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах, БД 43-101-03 12 Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ норм дүрэм стандартыг чанд мөрдөж ажиллана.
7. Ажиллах горим	24/7 горимд ажиллах боломжтой байх

Шалгалт, туршилт

Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор барааг хүлээн авахдаа захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.

